



**ДАРХАН ХОТЫН БОХИР УСНЫ МЕНЕЖМЕНТИЙГ
САЙЖРУУЛАХ МОН-3244/3245 ТӨСЛИЙН
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН 2022**

**БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ
ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР**

**УЛААНБААТАР ХОТ
2022 ОН**

Батлав:

БОАЖЯ-ны ХБОБНУГ-ын дарга

Г.Энхмөнх

Зөвшөөрч, хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн:

МОН-3244/3245 төслийн зохицуулагч

Ж. Түвшинбаяр

**ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ДАРХАН ХОТОД
ХЭРЭГЖИЖ БУЙ ДАРХАН ХОТЫН БОХИР УСНЫ
МЕНЕЖМЕНТИЙГ САЙЖРУУЛАХ МОН-3244/3245
ТӨСЛИЙН 2022 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

Төслийн дугаар: МОН-3244/3245

Хянасан:

БОАЖЯ-ны ХБОБНУГ-ын ахлах мэргэжилтэн

Ц.Жаргалнэмэх

Биелэлтийг тайлагнасан:

Зээл хэрэгжүүлэх байгаль орчны зөвлөх

Д. Одгэрэл

**Улаанбаатар хот
2022 он**

ГАРЧИГ

1. Төслийн товч танилцуулга	6
1.1. Төслийн ерөнхий мэдээлэл.....	6
1.2. Төслийн 2022 оны үйл ажиллагаа	9
2. Сөрөг нөлөөллөөс сэргийлэх, бууруулах, арилгах ажлын төлөвлөгөөний биелэлт.....	11
2022 онд төслийн үйл ажиллагаа 10 дугаар сарын 28-ны өдрөөс эхэлсэн ба БОМТ-ний биелэлтийн тайлан нэг сарын үйл ажиллагааг хамарч байна	11
2.1. Агаар орчинд үзүүлэх сөрөг нөлөөллөөс сэргийлэх, бууруулах, арилгах ажлын төлөвлөгөөний биелэлт.....	11
Төслийн хүрээнд 2022 онд агаар орчинд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах 6 арга хэмжээ төлөвлөсөн бөгөөд нийт гүйцэтгэл 100% байна.	11
2.2. Хөрсөн орчин, газрын хэвлийд үзүүлэх сөрөг нөлөөллөөс сэргийлэх, бууруулах, арилгах ажлын төлөвлөгөөний биелэлт.....	12
2.3. Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллөөс сэргийлэх, бууруулах, арилгах ажлын төлөвлөгөөний биелэлт.....	14
2.4. Ургамлын нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллөөс сэргийлэх, бууруулах, арилгах ажлын төлөвлөгөөний биелэлт.....	15
3. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө.....	15
Цэвэрлэх байгууламжийн шинэчлэн сайжруулалтын хүрээнд цэвэрлэх байгууламжийн талбайд болон түүний нөлөөллийн бүсэд ямар нэгэн түүх соёлын дурсгалт зүйл ба археологийн олдвортой газар одоогоор илрээгүй байна.	15
4. Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	16
5. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	17
6. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө	18
7. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр.....	20
8. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	28
9. Нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө	28
10.Химийн бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	29
10. Өргөдөл гомдол барагдуулах механизмын хэрэгжилт	30
11.Хавсралт.....	32
11.1. Төсөл хэрэгжүүлэгч “Дархан-Ус суваг” ХК-ийн гэрчилгээ.....	32
11.2. “Дархан-Ус суваг” ХК-ийн тусгай зөвшөөрөл.....	34
11.3. Тухайн жилийн БОМТ-г дүгнэсэн аймгийн дүгнэлт	35
11.4. 2022 оны БОМТ-ний батлагдсан нүүр хуудас	36
11.5. Байгаль орчны хяналт шинжилгээний ажлын тайлангийн батлагдсан нүүр	37
11.6. Усны микробиологийн шинжилгээний дүн	38
11.7. Усны хими болон хүнд металлын шинжилгээний дүн.....	40
11.8. Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хээрийн хэмжилт, дээжлэлт.....	43
11.9. Лабораториудын магадлан итгэмжлэлийн гэрчилгээ	45
11.10. НААҮГ-тай хог хаягдал ачиж, тээвэрлүүлэхээр байгуулсан гэрээ	46
11.11. Сургалтын мэдээлэл.....	49
11.12. Цахилгаан, ус ашиглах гэрээ	50
11.13. Байгаль орчны болон ХАБ ажилтан томилох тушаал	53
11.14. Техникийн үзлэг, тодорхойлолт	54

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Төсөл хэрэгжиж буй Дархан хотын цэвэрлэх байгууламж.....	7
Зураг 2. Төслийн талбайн байршил	8
Зураг 3. Нөхөн сэргээлтийн төлөвлөлтийн зураг.....	16
Зураг 4. ОХШХ-ийн цэгүүдийн байршил	21

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. ОХШХ-ийн үзүүлэлтүүд.....	20
Хүснэгт 2 Мониторинг хийсэн цэгийн үндэслэл болон координат.....	21

Хүснэгт 3. Шинжилгээний үр дүн, тоосонцор	23
Хүснэгт 4. Агаар бохирдуулагч бодисын шинжилгээний үр дүн.....	24
Хүснэгт 5. Дуу шуугианы хэмжилтийн үр дүн	24
Хүснэгт 6. Бохир усны хүнд металлын шинжилгээний үр дүн	25
Хүснэгт 7. Бохир усны шинжилгээний үр дүн.....	26
Хүснэгт 8. 2022 оны 11-р сарын усны микробиологийн шинжилгээний дүн.....	27

Товчилсон үгсийн жагсаалт

АХБ	Азийн Хөгжлийн Банк
БОАЖЯ	Байгаль орчин, аялал жуулчлалын яам
БОМТ	Байгаль орчны менежментийн төлөвлөгөө
БОНБҮ	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ
БОЭҮ	Байгаль орчны эрсдэлийн үнэлгээ
БХБЯ	Барилга, хот байгуулалтын яам
БХХ	Биохимийн хэрэгцээт хүчилтөрөгч
БУШС	Бохир усны шугам сүлжээ
ДУС ХК	Дархан Ус суваг ХК
ДЦС	Дулааны цахилгаан станц
ЗХЗ	Зээл Хэрэгжүүлэх Зөвлөх
ОАЭҮ	Осол, аюулын эрсдэлийн үнэлгээ
ӨГБМ	Өргөдөл, гомдол барагдуулах механизм
ЦБ	Цэвэрлэх байгууламж
ПИЧ	Перманганатын исэлдэх чанар
ТУН	Төслийн Удирдах Нэгж
УТБ	Ус түгээх байр
ХХХ	Химийн хэрэгцээт хүчилтөрөгч
ХЭМЭҮ	Хүний эрүүл мэндийн эрсдэлийн үнэлгээ

1. Төслийн товч танилцуулга

1.1. Төслийн ерөнхий мэдээлэл

Төслийн нэр:

“Дархан хотын бохир усны менежментийг сайжруулах” төсөл

Төслийн зорилго:

“Дархан-Ус суваг” ХК нь Дархан сумын нийт ард иргэдийг цэвэр усаар ханган ажиллах үүрэгтэй онцгой байгууллага юм. Төсөл хэрэгжсэнээр Дархан хотын хүрээлэн буй орчныг сайжруулах ажилд болон олон улсын гол, мөрний усны чанарын стандартыг хангах хэмжээнд Хараа голын усны чанарыг сайжруулахад хувь нэмэр оруулна. Төслийн хүрээнд Дархан хотын бохир усны шугам сүлжээ болон төв цэвэрлэх байгууламжийг шинэчилнэ.

Төсөл хэрэгжүүлэгч:

Барилга хот байгуулалтын яам, “Дархан-Ус суваг” ХК

Регистрийн дугаар: 2736012

Тусгай зөвшөөрлийн дугаар: 00274

Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг:

Дархан-Уул аймаг, Дархан сумын 8-р баг

Утас: 99372232, 99372088

Төслийн ерөнхий мэдээлэл:

Дархан хотын бохир усны менежментийг сайжруулах МОН3244/3245 төслийн зорилт нь дараах үндсэн 3 бүрэлдэхүүн хэсгээс бүрдэнэ.

Үр дүн 1: Бохир ус цэвэрлэх байгууламжийг шинэчлэх

Төслийн үр дүнд орчин үеийн Үйлдвэрлэлийн бүтээмж өндөртэй, эрчим хүчний хэмнэлттэй цэвэрлэх процесс болох биофильмт технологийг (идэвхжүүлсэн лаг) ашиглах шинэ цэвэрлэх байгууламж ашиглалтад орох бөгөөд нийт барилга байгууламж болон тоног төхөөрөмжийг шинээр барьж суурилуулж тоноглоно. Манай орны эрс тэс уур амьсгалд зохицсон технологийг нэвтрүүлснээр цэвэрлэх байгууламжаас гарах хаягдал усны чанар, дотоодын болон олон улсын стандартын шаардлагын түвшинд хүрнэ. Бохир усны цэвэрлэх хүчин чадлын өдрийн хэвийн үеийн ачаалал нь 16,000 шоо метр, оргил ачаалал нь өдрийн 24,000 шоо метр байна.

Төслийн энэ үр дүнгийн хүрээнд мөн одоо ашиглагдаж буй 2, ашиглалтгүй байгаа 1 насос станцыг бүрэн шинэчилж тоноглогоор цэвэрлэх байгууламжид төвлөрөх бохир усны цуглуулалтыг ихэсгэж эрчим хүчний хэмнэлттэй цэвэрлэх боломжийг бий болгоно. Мөн орчин үеийн цэвэр бохир усны лаборатори ашиглалтад орсноор усны чанарыг олон улсын стандартуудад нийцүүлэн шинжилж үр дүнг гаргадаг болно.

Үр дүн 2: Дулааны болон бохирын шугам хоолой шинэчлэгдэнэ.

Төслөөр ашиглалтын шаардлага хангахгүй болсон нийт 9,2 км урт бохир усны шугам хоолойг шинэчилж, өргөтгөнө. Ингэснээр үйлдвэрүүдийн бохир усыг урьдчилсан цэвэрлэх байгууламжаар дамжуулан төв цэвэрлэх байгууламжид нийлүүлэх, мөн хотын төвийн хэрэглэгч ихтэй шугамуудын ачааллыг багасгаснаар найдвартай ажиллагаа дээшлэх нөхцөл бий болно.

Цэвэрлэх байгууламжийг төвийн дулааны сүлжээнд холбох зорилгоор 1,2 км дулааны хос шугам хоолойг шинээр, дулааны 3-р насос станцын тоног төхөөрөмж болон цахилгаан тоноглолыг шинэчилнэ. Цэвэрлэх байгууламж төвийн дулаанд холбогдсоноор цаашдын ашиглалтын зардал буурч, ажилчдад ажиллах таатай нөхцөл бүрдэнэ. Мөн түүнчлэн “ДУС” ОНӨХК-ийн өдөр тутмын

үйл ажиллагаанд хэрэглэгдэх үйлчилгээний зориулалттай тоног төхөөрөмж төслийн хүрээнд нийлүүлэгдэж, ажлын хөдөлмөрийн бүтээмжийг сайжруулна.

Үр дүн 3: Төслийн менежментийн дэмжлэг ба чадавхыг бэхжүүлэх

Төслийн менежмент, институцийг бэхжүүлэх: НАА-н салбарын менежментийн чадавхыг хөгжүүлэх, ашиглалт ба засвар үйлчилгээг сайжруулах, онцгой байдлын үед авах арга хэмжээг нарийвчилсан зураг төсөл боловсруулан хэрэгжүүлж, түүнд хяналт тавьж мэргэжлийн дэмжлэг үзүүлэх боломжийг бий болгоно.

Төслийн удирдах нэгжийн чадавхыг бэхжүүлэх: Төслийн хэрэгжилтийн явцад сургалт болон сургалтын аяллууд зохион байгуулагдана. Төслийн хэрэгжилтийн явцад цэвэр ба бохир усны үнэ тарифын шинэчлэл, ариун цэврийн орчин болон хатуу хог хаягдлын менежментийг сайжруулах талаар бодлого тодорхойлох яриа хэлэлцүүлэг хийнэ. Байгаль орчны менежмент, ариун цэвэр ба хатуу хог хаягдлын менежментийг сайжруулах талаар олон нийтийг хамруулсан компанит ажил зохион байгуулна.

Төслийн байршил:

Дархан хот орчмын нутаг нь хөрс газарзүйн мужлалаар био-уур амьсгалын Хангайн мужийн холимог бүсшил бүхий Орхон-Туулын дэд мужийн 14 дүгээр тойрогт багтана. Энэ тойрогт хар хүрэн, нимгэн хүрэн, нугын хүрэн, уулын ширэгт тайгын хөрс, Хараа голын татмаар аллювийн ширэгт хөрс тархана.


Дархан хот нь Хараа голын сав газрын зүүн талд, нам ухаа гүвээрхэг, талархаг газар д.т.д 700-850 м орчим өндрийн түвшинд байрлана. Хотын орчимд Хараа голын хөндий 3 км орчим өргөн байх бөгөөд Орхон голтой нийлэх үедээ 8-10 км өргөн болдог байна. ТЦБ нь Хараа голын татмын дээрх дэнж дээр байрлана. Энд аллювийн хурдас тархсан ба түүний дээд хэсгээр делюви-поллювийн гаралтай маш нарийн ширхэгтэй элс, элсэнцэр, шавранцар хөрстэй.

Дархан-Ус суваг ХК-ийн үндсэн хэсгүүдийг холбосон цэвэр, бохир ус дамжуулах шугам хоолой, худаг, насос станцууд, УТБ-ууд нь делюви-поллювийн, элювийн, эолын хурдас зонхилон тархсан талбайд байгуулагдсан байдаг. Тус бүсэд физик-геологийн үзэгдэл, үйл явц эрчимтэй хөгжсөн бөгөөд салхины гаралтай хурдас хуримтлал, хөрсний овойлт, хагарал, голын идэгдэл, үер, намагшилт, талбайн угаагдал, физик өгөршил, халиа тошин зэрэг үйл явц, үзэгдлүүд үүсдэг.

Төслийн талбай нь Улаанбаатараас баруун хойшоо 230 км зайд орших бөгөөд Дархан-Уул аймгийн Дархан суманд байрлана.

Зураг 1. Төсөл хэрэгжиж буй Дархан хотын цэвэрлэх байгууламж





Зураг 2. Төслийн талбайн байршил

1.2. Төслийн 2022 оны үйл ажиллагаа

Уг төсөл нь 2016 онд эхэлсэн бөгөөд 2018 оноос барилгын ажил эхэлсэн. 2022 онд төслийн үндсэн гүйцэтгэгч Пфайффер ба Эмит хамтралтай байгуулсан гэрээг цуцалсан ба 2022 оны 09 сарын 21-ны өдөр АХБ-аас ирүүлсэн зөвшөөрлийн дагуу Байгууламж ХХК-тай 2022 оны 10 сарын 26-ны өдөр ажил гүйцэтгэх А1-1 2022/499 гэрээг албан ёсоор байгуулан шинэчилсэн ерөнхий төлөвлөгөө батлуулан ажиллаж байна. Гэрээний дагуу 2023 оны 03 сарын 31-нд төслийн барилга угсралтын ажлыг бүрэн хийж дуусгах ба тайлангийн хугацаанд ажлын нийт гүйцэтгэл 87.3%, харин бүрэлдэхүүн тус бүрээр дараах биелэлттэй байна.

Бүрэлдэхүүн 1. Дархан хотын бохир ус цэвэрлэх байгууламжийн шинэчлэл, насос станц болон 12 сарын зүгшрүүлэлтийн дэмжлэг үзүүлэлэлтийн гүйцэтгэл 80% байна. Дархан хотын бохир ус цэвэрлэх байгууламжийн шинэчлэл, насос станцын засвар шинэчлэлийн ажлын хүрээнд 41 барилга байгууламжийн шинэчлэл хийгдэхээс 2022 оны 11 сарын байдлаар 23 барилгын ажил дуусаж, 15 барилгын ажил үргэлжлэн хийгдэж, 3 барилгын ажил бусад ажилтай уялдаа хамааралтайгаар эхлээгүй байна.

Тайлангийн хугацаанд Гүйцэтгэгч дараах үйл ажиллагааг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

1. Агааржуулах станц дэд өртөөний барилга:
 - Гадна дотор заслын ажил дулаалга, фасад
 - Цахилгааны тоног төхөөрөмж угсралт
 - Тоноглолын агааржуулалтын хоолой холболт
 - Даралттай агаарын шугамын угсралтын ажил
 - Бетон шал цутгалт
2. Ферик хлоридийн агуулах:
 - Гадна дотор засал
 - Хаалаг цонх суурилуулалт
 - Дээврийн хормой хайрцаг угсралт
 - Бетон шал цутгалт
3. Аеротенкийн барилга:
 - Гадна хар лак түрхлэг
 - Тайны нүхны бөглөж костероор шавах
 - Хүн явах хэсгийн арматурчлал бетон цутгалт
 - Процессийн шугамын холболт
 - 1-р үеийн буцаан булалт
4. Эргэлтийн болон илүүдэл лаг цуглуулах камер:
 - Процессийн шугамын холболт
 - Тоног төхөөрөмжийн угсралт
5. Аеротенкийн ус хуваарилах камер:
 - Улаан шугам газар шорооны ажил
 - Ул бетон цутгалт суурийн ажил
 - Арматурчлал хэв хашлага угсралт
 - Процессийн шугамын холболт
6. Нарийн сараалжны барилга:
 - Тоног төхөөрөмж угсралт
 - Дээврийн үлдэгдэл ажил
 - Бетон шал цутгалт
 - Цахилгааны тоноглол угсралт
 - Агааржуулалтын систем угсралт

7. Ахуйн бохир хүлээн авах байгууламж:

- Дээврийн үлдэгдэл ажил
- Механик тоног төхөөрөмж угсралт
- Ахуйн бохирын шугам хоолой угсралт
- Процессийн шугам хоолой угсралт зэрэг ажлууд хийгдэж байна.

Барилгын ажил дууссан барилга байгууламжуудад тоног төхөөрөмж угсралтын ажил үргэлжлэн хийгдэж байна.

- Нийт бетон цутгалтын 98% хийгдсэн.
- Хийц бүтээц арматурчлалын 95% угсрагдсан.
- Тоног төхөөрөмж угсралтын 33% хийгдсэн.
- Технологийн шугам хоолой угсралтын 80% хийгдсэн.
- Ахуйн бохир хүлээн авах шугам хоолой угсралт 100% дууссан.
- Буцаан булалт дүүргэлтийн ажил 55%-ийн гүйцэтгэлтэй.
- Цахилгаан, механик тоног төхөөрөмж худалдан авалтын 82% төслийн талбайд нийлүүлэгдсэн.

Бүрэлдэхүүн 2. Үйлдвэрийн бүсийн насос станцын шинэчлэл, дулааны болон бохирын шугам хоолой солих ажлын тухайд А1 багц ажлын гүйцэтгэлтэй холбоотойгоор 2022 онд ямар нэгэн ажил хийгдээгүй багцын гүйцэтгэл 93% хэвээрээ байна. Шинэчилсэн гэрээний дагуу ажлын дуусах хугацааг 2023 оны 06 сар хүртэл хойшлуулсан.



Бүрэлдэхүүн 3. Төслийн удирдлагын дэмжлэг болон чадавхи бэхжүүлэх ажлын гүйцэтгэл 89% тус тус байна.



2. Сөрөг нөлөөллөөс сэргийлэх, бууруулах, арилгах ажлын төлөвлөгөөний биелэлт

2022 онд төслийн үйл ажиллагаа 10 дугаар сарын 28-ны өдрөөс эхэлсэн ба БОМТ-ний биелэлтийн тайлан нэг сарын үйл ажиллагааг хамарч байна.

2.1. Агаар орчинд үзүүлэх сөрөг нөлөөллөөс сэргийлэх, бууруулах, арилгах ажлын төлөвлөгөөний биелэлт


Төслийн хүрээнд 2022 онд агаар орчинд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах 6 арга хэмжээ төлөвлөсөн бөгөөд нийт гүйцэтгэл 100% байна.

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Биелэлт	%	Баримт
1	Цэвэрлэх байгууламжийн хамгаалалтын постоос эхлэн барилга байгууламжуудыг холбосон байнгын ашиглалтад байх зам талбайд хатуу хучилт хийх	Төсөл дуусах хугацаа 2023 оны 3 дугаар сарын 31 ныг хүртэл сунгагдсан тул Цэвэрлэх байгууламжийн зам талбайн хучилтын ажил 2023 онд хийгдэнэ.	-	-
2	Барилгын ажил болон А1 суваг ухалтын ажлыг 4 - 11 сарын хооронд гүйцэтгэхэд агаарын температур +5 °C-аас дээш байх үед хуурай болон хэт хуурай нөхцөлд зам услах ажлыг 2-3 цагийн зайтай тогтмол хугацаанд гүйцэтгэнэ. Усалгаанд 4.104 тн ус зарцуулагдахаар тооцсон.	Хур тунадас багатай үед агаарын тоосжилт бууруулах усалгааг ажилчдын байр, барилгын талбайн түр зам дагуу буюу 0.5 га газарт 2 удаа хийж гүйцэтгэсэн.	-	Барилгын ажил 10 дугаар сарын 28ны өдрөөс эхэлсэн тул тоосжилт бууруулах усалгаа хийгдээгүй.
3	Төсөл хэрэгжүүлэхэд ажиллах хүнд даацын тээврийн хэрэгслүүд, механизмуудын дуу чимээ орчиндоо тархан дуу чимээний бохирдол үүсгэх бөгөөд ойролцоох айлуудад сөрөг нөлөө үзүүлнэ. Иймд айлуудад сонсогдох чимээ 45 Дб давсан үед иргэдийн амрах цагаар ажиллах цагийн горимыг зохицуулж ажиллах шаардлагатай.	Төсөл хэрэгжүүлэх явцад үүсэх дуу чимээний бохирдлоос сэргийлж, ажлын цагаар буюу 08:00-19:00 цаг хүртэл ажилласан. Төслийн талбайд ажиллаж буй техник хэрэгсэл, машин механизм дуут дохионы шаардлагыг хангаж ажилласан.	100	
4	Төслийн хүрээнд ажиллах техникүүдийн бүрэн бүтэн байдал, яндангаас гарах угаарыг хэмжих ажлыг зохион байгуулах, тогтмол шалгаж, техникийн үйлчилгээ хийсэн тухай паспорт хөтлөх шаардлагатай..	Төсөл хэрэгжүүлэх явцад гүйцэтгэгч компани нь 4510УБЧ Isuzu, 9202 УБН Doosan, 1972 УБН Volvo, 5999ДАН Hovo, 2057УН Longgong, 0937УН Hyundai маркийн машин техникүүдийг ашиглаж байна. Эдгээр машиныг техникийн үзлэгт хамруулсан болно.	100	 Дэлгэрэнгүйг Хавсралт аас харна уу.

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Биелэлт	%	Баримт
5	Химийн бодис, материалын хадгалалтын нөхцөлийн стандартыг нарийн баримталж уурших, халах, тэлэх нөхцөлөөс бүрэн сэргийлж ажиллах. Химийн бодисыг хадгалахдаа ХАЛМ-д заасны дагуу хадгалах.	Төсөл хэрэгжүүлэгч Дархан Ус суваг ХК нь Химийн бодис ашиглах тусгай зөвшөөрлийг мэргэжлийн байгууллагаас авч ашиглаж байна. Төслийн талбайд химийн хортой аюултай бодис ашигладаггүй.	100	
6	Үйлдвэрт ашиглаж буй эргэлтэд цахилгаан тоног төхөөрөмжүүдийн хэвийн үйл ажиллагаа доголдсоноос үүдэн орчинд тархах дуу чимээ нэмэгдэж орчиндоо дуу чимээний бохирдол үүсгэж болзошгүй юм. Иймд тоног төхөөрөмжийн хэвийн ажиллах нөхцөлийг хангаж орчинд 45-60 Дб дээш дуу чимээний бохирдол үүсгэхгүй байх шаардлагатай. Дуу чимээ ихтэй төхөөрөмжийн гадна барилгын битүүмжийг сайтар хийх.	2022 оны 11 дүгээр сард дуу шуугианы үзүүлэлтийг барилгын ажил явагдаж байгаа талбай болон төслийн талбайн гадна хяналтын цэгт хэмжсэн. Хэмжилтийн утгыг “MNS4585:2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага” стандарттай харьцуулах ба тайланг бэлтгэх үед мониторингийн тайлан гарч амжаагүй байв.	100	
Нийт биелэлт			100	

2.2. Хөрсөн орчин, газрын хэвлийд үзүүлэх сөрөг нөлөөллөөс сэргийлэх, бууруулах, арилгах ажлын төлөвлөгөөний биелэлт

Төслийн хүрээнд 2022 онд хөрсөн орчин, газрын хэвлийд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, урьдчилан сэргийлэх 5 арга хэмжээ төлөвлөсөн бөгөөд нийт гүйцэтгэл 100% байна.

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Биелэлт	%	Фото зураг
1	Төслийн талбайд тавигдсан байгаа замын тэмдэг тэмдэглэгээ, маршрутын дагуу хүнд даацын машин механизмыг зорчуулж газрын гадарга эвдэгдэхээс сэргийлж ажиллах. Тэмдэг тэмдэглэгээг сайжруулах	Барилгын ажлын явцад түр ашиглах зам талбайг бэлтгэн, төлөвлөсөн замаас бусад талбайгаар зорчихгүй байж, хашилт хаалт хийж, тэмдэгжүүлсэн.	100	

2	<p>Барилга байгууламжийн суурийн газар шорооны ажлыг гүйцэтгэхдээ барилгын ажил гүйцэтгэгч талууд, ИТА-ууд барилга эхлэх улаан шугамын хүрээнээс илүү талбайг хөндөхгүй ажиллах</p>	<p>Барилга байгууламжийн суурийн газар шорооны ажлыг гүйцэтгэхдээ барилгын ажил гүйцэтгэгч талууд, ИТА-ууд барилга эхлэх улаан шугамын хүрээнээс илүү талбайг хөндөхгүй ажилласан. Төслийн газар шорооны ажил өмнөх тайлангийн хугацаанд гүйцэтгэгдсэн ба 2022 онд дулааны болон бохирын шугам хоолойн ажил төслийн талбайд хийгдсэн.</p>	100	
3	<p>Машин техникийн засвар үйлчилгээг зориулалтын засвар үйлчилгээний газарт хийх.</p>	<p>Төслийн талбайд машин засвар үйлчилгээг хийж гүйцэтгэдэггүй. Төслийн гүйцэтгэгч нь машин механизмын засвар үйлчилгээг барилгын ажлын өмнө хийж, техникийн үзлэг оношилгоонд оруулсан бөгөөд хэрвээ машин механизмд засвар гэмтэл гарсан тохиолдолд зөвшөөрөл бүхий газарт засвар үйлчилгээг хийж гүйцэтгэдэг.</p>	100	
4	<p>Зөвшөөрөгдсөн хог хаягдлын цэгээс бусад газар хог хаягдал хаяхгүй, газрын төрх, хөрсийг эвдэхгүй, хөндөхгүй байх арга хэмжээг хэвшүүлэх</p>	<p>Төслийн талбайд ахуйн хог хаягдал цуглуулах цэгийг төлөвлөн байршуулж, Дархан Уул аймгийн НААҮГ тай байгуулсан гэрээний дагуу хог хаягдлын төвлөрсөн цэгт хүргүүлж ажилласан.</p>	100	
5	<p>Болзошгүй байдлаар химийн бодис асгарсан тохиолдолд саармагжуулах хэрэгсэл болох шингээгч, хуурай элс, тогтворжуулагч, үртэс зэргийг бэлэн байлгах. Асгарсан тохиолдолд ХАЛМ -д заасны дагуу арга хэмжээ авах.</p>	<p>Болзошгүй байдлаар химийн бодис асгарсан тохиолдолд саармагжуулах хэрэгсэл болох элс, үртэс, цуглуулах хогийн савыг төслийн талбайд байршуулсан.</p>	100	
Нийт биелэлт				100




2.3. Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллөөс сэргийлэх, бууруулах, арилгах ажлын төлөвлөгөөний биелэлт

Төслийн хүрээнд 2022 онд усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, урьдчилан сэргийлэх 6 арга хэмжээ төлөвлөсөн бөгөөд нийт гүйцэтгэл 100% байна.

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Биелэлт	%	Фото зураг
1	Төслийн А1 багцын хүрээнд зам усалгаанд 1.9 га-д цэвэр усны нөөцөөс 4.104 тн ус зарцуулагдана. Иймд тус тооцоологдсон хэмжээнээс хэтрүүлэн ус ашиглахгүй ажиллах шаардлагатай.	Барилгын ажил 10 дугаар сарын 28ны өдрөөс эхэлсэн тул тоосжилт бууруулах усалгаа хийгдээгүй.	-	-
2	Төслийн А1 багцын хүрээнд 3.56 га талбайн усалгаанд цэвэр усны нөөцөөс нийт 9.792 тн ус авч ашиглахаар байна. Иймд тус тооцоологдсон хэмжээнээс хэтрүүлэн ус ашиглахгүй ажиллах шаардлагатай.	Дархан-Уул аймгийн Дархан Ус суваг ХК-тай ус ашиглах гэрээ байгуулж, хэрэглээний усаа тоолууржуулж тооцоологдсон хэмжээнээс хэтрүүлэн ашиглаагүй, ус ашигласан төлбөрийг сар бүр тогтмол төлсөн.	100	Ус ашиглах гэрээг хавсаргав. Хавсралт 11.14
3	Тус төслийн бүтээн байгуулалт болон цэвэрлэх байгууламжийн үйл ажиллагааны явцад унд ахуйн хэрэглээнд шаардлагатай усны төлбөрийг цаг тухайд нь төлж барагдуулах.	Ус ашигласан төлбөрийг сар бүр тогтмол төлсөн.	100	Ус ашиглах гэрээг хавсаргав. Хавсралт 11.14
4	Бохирдол ихтэй усыг хүлээн авснаар ЦБ-ийн үйл ажиллагаа доголдох, Хараа голд нийлүүлэх бохир усны стандарт зөрчигдөх аюултай. Иймд ААНБ-аас нийлүүлэгдэж буй усанд байнгын хяналт тавьж ажиллах шаардлагатай. Шинээр төвийн бохир усны системд холбогдохоор төлөвлөж буй байгууллагын бага оврын цэвэрлэх байгууламжуудад тогтмол хяналт тавьж, шаардлагатай зөвлөмж, шаардлагыг цаг тухай бүр хүргүүлж холбогдох арга хэмжээг авч ажиллана.	Хяналтын худгуудаас бохир усны дээж авч, химийн болон микробиологийн шинжилгээ хийлгэсэн бөгөөд төслийн талбайн орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусган ажилласан. Усны шинжилгээг магадлан итгэмжлэгдсэн “Хан Лаб” ХХК-тай гэрээлэн хийлгэдэг.	100	ОХШХ-ийн хэрэгжилт хэсгээс дэлгэрэнгүй үзнэ үү.
5	ЦБ-ийн хаягдал дахь хортой, аюултай болон бусад төрлийн химийн бодис, умбуурт бодис, БХХ, ХХХ хүлцэх агууламжаас давж хаягдаж, технологийн горим зөрчигдсөн тохиолдолд лагийн талбайгаар дамжин гүний усанд бохирдол үүснэ. Иймд бохир ус нийлүүлэгч ААНБ-уудад хяналт тавьж ажиллах шаардлагатай.	Хяналтын худгуудаас усны дээж авч, химийн болон микро биологийн шинжилгээ хийлгэсэн бөгөөд төслийн талбайн орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусган ажилласан. Усны шинжилгээг магадлан итгэмжлэгдсэн “Хан Лаб” ХХК-тай гэрээлэн хийлгэдэг.	100	ОХШХ-ийн хэрэгжилт хэсгээс дэлгэрэнгүй үзнэ үү.
6	Бохирын шугам хоолойн битүүмж алдагдан цоорч, хагарсан тохиолдолд тухайн орчны хөрсөнд бохирдол үүсгэнэ. Иймд шугам хоолойн бүрэн байдлын тогтмол хянаж, гэмтэл гарсан тохиолдолд яаралтай засварлах, бохирдсон хөрсийг битүүмжлэх шаардлагатай.	Шугам хоолойн бүрэн байдал, засвар үйлчилгээг “Дархан Ус Суваг” ХК хариуцан ажиллаж, тогтмол хяналт тавьдаг. Шугам хоолойн гэмтэл 2022 онд гараагүй.	100	-
Нийт биелэлт			100	

2.4. Ургамлын нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллөөс сэргийлэх, бууруулах, арилгах ажлын төлөвлөгөөний биелэлт

Төслийн хүрээнд 2022 онд ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, урьдчилан сэргийлэх 3 арга хэмжээ төлөвлөсөн бөгөөд нийт гүйцэтгэл 100% байна.


№	Төлөвлөсөн арга хэмжээ	Биелэлт	%	Фото зураг
1	Цэвэрлэх байгууламжийн талбайд ургамлын хяналт шинжилгээний ажлыг хийж байх.	2022 онд барилгын ажил 11 дүгээр сараас эхэлсэн тул 11 дүгээр сард хийсэн хяналт шинжилгээнд ургамлын хяналт хамрагдаагүй.	-	-
2	Замын нэгдсэн маршрут гаргаж барилгын ажлын явцад түр ашиглах зам талбай бэлтгэх шаардлагатай. Төлөвлөсөн замаас бусад талбайгаар зорчихгүй байж, хашилт хаалт хийж, тэмдэгжүүлэн ажиллана.	Барилгын ажлын явцад түр ашиглах зам талбайг бэлтгэн, төлөвлөсөн замаас бусад талбайгаар зорчихгүй байж, хашилт хаалт хийсэн.	100	
3	Барилгын талбайн 10 чацарганы модыг арчилж тордох	Ажилчдын байрны урд байрлалтай 10 чацарганы модыг сард 2 удаа арчилгаа, тордолгоог хийж бүртгэл хийсэн ба хамгаалалтын тор татсан.	100	
	Төлөвлөгөөнөөс гадуур хийсэн бусад ажил	Цэвэрлэх байгууламжийн төслийн талбайд 10 ширхэг нарс модыг ТУН ийн ажиллагсад өөрсдийн дотоод бололцоогоор тарьж, арчилгаа тордолтыг хийсэн.		
Нийт биелэлт			100	

3. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Цэвэрлэх байгууламжийн шинэчлэн сайжруулалтын хүрээнд цэвэрлэх байгууламжийн талбайд болон түүний нөлөөллийн бүсэд ямар нэгэн түүх соёлын дурсгалт зүйл ба археологийн олдвортой газар одоогоор илрээгүй байна.

4. Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

Төслийн хүрээнд 2022 онд орчны тохижилт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний техникийн ба биологийн нөхөн сэргээлтэд 2 арга хэмжээ төлөвлөсөн бөгөөд Нөхөн сэргээлтийн гол зорилго нь төсөл хэрэгжих газрын байгаль, цаг уурын онцлогт тохируулан төслийн газар шорооны ажлын үед өртсөн газар, хөрсөн, ургамлан орчныг сэргээх, ТЦБ-ын орчинд ногоон байгууламжийг барьж байгуулах явдал юм. А1 багцын хүрээнд Дархан хотын бохир ус цэвэрлэх байгууламжийг шинэчлэх ажлын төлөвлөгөөгөөр 35 объект баригдаж нийт 4.5 га талбай эвдрэлд өртөхөөр тооцоолсон. Үүний 2.5 га-д нь барилга байгууламж баригдаад **2.0 га** талбай техникийн болон биологийн нөхөн сэргээлт гадаад тохижилтын ажил хийгдэнэ. Ногоон байгууламжийн төлөвлөлтийг урьдчилсан байдлаар дараах зурагт харуулав. Ногоон байгууламжийг шинээр баригдсан барилга байгууламж зам дагуу ногоон байгууламжийг хийхээр төлөвлөсөн байна.






Зураг 3. Нөхөн сэргээлтийн төлөвлөлтийн зураг

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Биелэлт	%	Фото зураг
1	Төслийн үйл ажиллагааны улмаас эвдэрсэн газарт техникийн нөхөн сэргээлт гүйцэтгэх	Төсөл дуусах хугацаа 2023 оны 3 дугаар сарын 31 болж сунгагдсантай холбоотой тайлангийн хугацаанд нөхөн сэргээлтийн ажил хийгдээгүй.	-	-
2	Төслийн үйл ажиллагааны улмаас эвдэрсэн газарт биологийн нөхөн сэргээлт гүйцэтгэх	Төсөл дуусах хугацаа 2023 оны 3 дугаар сарын 31 болж сунгагдсантай холбоотой тайлангийн хугацаанд нөхөн сэргээлтийн ажил хийгдээгүй.	-	-

5. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө




Төслийн хүрээнд 2022 онд осол, эрсдэлийн менежментийн 3 арга хэмжээ төлөвлөсөн бөгөөд нийт гүйцэтгэл 100% байна.


№	Төлөвлөсөн арга хэмжээ	Биелэлт	%	Фото зураг
1	Гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлж сургалт зохион байгуулах, галаас хамгаалсан зурвас татах, гал унтраах багаж хэрэгсэл бэлтгэх зэрэг ажлыг хэрэгжүүлнэ. Дээр дурдсан ажлуудыг аюул, ослын үед байгууллагын дотоодод хэрэгжүүлэх аюул, ослын үед ажиллах төлөвлөгөөнд тусгана.	Гал унтраахад шаардлагатай хэрэгслийг ажилчдын байр болон захиргааны барилгын үүдэнд байршуулсан.	100	
2	ЦБ-ийн одоо байршиж буй байршил нь уулын бэл хормой, Хараа голын хуучин татамд байрлаж байгаа учир үер усны аюулаас урьдчилан сэргийлэн үерийн далан хийж, шуудуу татах шаардлагатай. Дээр дурдсан ажлуудыг аюул, ослын үед байгууллагын дотоодод хэрэгжүүлэх аюул, ослын үед ажиллах төлөвлөгөөнд тусгана.	Хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны нийтлэг журамд хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах талаар ажилтны хүлээх үүрэг_ аюулгүй ажиллагаанд тавигдах шаардлага, аюул ослын үед ажиллах зааварчилгааг тусган, мөрдөж ажилласан.	100	

3	Хувийн хамгаалах хэрэгслийн хэрэглээ, төслийн талбайд ажиллах аюулгүй ажиллагааны зааварчилгаа гэх мэт агуулга бүхий, гэнэтийн ослоос урьдчилан сэргийлэх сургалт зохион байгуулах. Эрсдэлтэй газруудад тэмдэг тэмдэглэгээ байршуулах, Эмнэлгийн анхны тусламжийн хайрцгийг тогтмол шалгаж, бүрэн байдлыг хангах	Ажилчдыг хөдөлмөр хамгааллын зохих хэрэгслээр бүрэн хангаж, өдөр бүр ажилд гарахын өмнө ХАБЭА-н зааварчилгааг өгч ажилласан. ХАБЭА-н сургалтыг нэгдсэн журмаар бүх ажилчдыг хамруулан 1 удаа зохион байгуулж нийт 22 хүн сургалтад хамрагдсан. Сургалтын бүртгэлийг хавсралтаас үзнэ үү.	100	
Нийт биелэлт				100

6. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө

Төслийн хүрээнд 2022 онд хог хаягдлын менежментийн 8 арга хэмжээ төлөвлөсөн бөгөөд нийт гүйцэтгэл 88% байна.

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Биелэлт	%	Фото зураг
1	Ажилчдад хог хаягдлын менежментийн сургалт явуулах	Төслийн талбайд барилгын ажил 2022 оны 11 дүгээр сард эхэлсэн тул ажиллагсад зориулсан хог хаягдлын сургалт хийгдээгүй.	-	-
2	Ахуйн хатуу хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан хаях, хогийн сав байрлуулах	Ахуйн хатуу хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан хаях, хогийн савыг нийт 3 цэгт байрлуулсан.	100	
3	Ахуйн хатуу хог хаягдлыг ангилан цуглуулах, хог хаягдлыг татан төвлөрүүлэх түр цэг байгуулах	Ахуйн хатуу хог хаягдлыг ангилан цуглуулах, хог хаягдлыг татан төвлөрүүлэх түр цэг байгуулсан.	100	
4	Хог хаягдлын цэгийг тогтмол ариутгаж байх	Ариутгал, халдваргүйжүүлэлтийг хог хаягдлын цэг, ажилчдын байрны ойролцоо “Дархан цэвэр орчин” ХХК-ийн халдваргүйжүүлэлтийг хэрэглэх зааврын дагуу 1 удаа хийж гүйцэтгэсэн.	100	

5	Ахуйн хог хаягдлыг тээвэрлэхдээ Дархан сумын НААҮГ-тай гэрээ байгуулж ажиллах	Ахуйн хог хаягдлыг тээвэрлэхдээ Дархан сумын НААҮГ-тай гэрээ байгуулж ажилладаг. Хавсралтаас гэрээний хуулбарыг үзнэ үү.	100	
6	Барилгын хог хаягдлыг ахуйн хаягдлаас тусад нь хуримтлуулах, НААҮГ-тай гэрээ байгуулах	Барилгын ажлын явцад үүссэн нийт 8 м ³ барилгын хог хаягдлыг ахуйн хаягдлаас тусад нь хуримтлуулан, НААҮГ-тай гэрээ байгуулан, ачуулсан.	100	
7	Химийн бодисын сав баглаа боодлыг үйлдвэрийн талбайд тусгай контейнерт хадгалах	Тайлант онд химийн бодис ашиглаагүй	100	-
8	Зайлшгүй тохиолдолд химийн бодисын сав баглаа боодлын хог хаягдал гарвал үйлдвэрийн талбайд тусгай контейнерт хадгалах. Хогны тухай хуулийн 23 зүйлд заасны дагуу аюултай хог хаягдлыг эх үүсвэр дээр нь түр хадгална. Хоёрдогч түүхий эдийн хог хаягдлыг ангилан ялган тусгай цэгт цуглуулж, төвлөрсөн цэгт тушаах, ШТМ-ын хаягдлыг хуримтлуулан хаягдал авах газарт хүргүүлэх	Дахин ашиглах боломжтой хуванцар хог хаягдлыг газар дээр нь ангилах сав байршуулсан ба тайлангийн хугацаанд ийм төрлийн хог хаягдал гараагүй. Цаашид орон нутгийн дахивар авах байгууллагатай гэрээ байгуулан хамтран ажиллана. Төслийн талбайд химийн бодис ашиглаагүй ба химийн бодисын сав баглаа боодлын хог хаягдал үүсээгүй болно.	100	-
Нийт биелэлт			88	



7. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр


Дархан хотын бохир усны менежментийг сайжруулах МОН 3244/3245 төслийн А1 Багцын хүрээнд шинээр баригдах цэвэрлэх байгууламжийн талбайн 2022 оны Байгаль орчны хяналт шинжилгээг 2 удаа хийхээр тухайн жилийн БОМТ-ний ОХШХ-т тусгагдсан. Төслийн үйл ажиллагаанаас шалтгаалж буюу өмнөх гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээг цуцалж, шинэ гүйцэтгэгч Байгууламж ХХКтай 2022 оны 10 дугаар сарын 28 ны өдөр гэрээг байгуулан ажиллаж байгаатай холбогдуулан орчны хяналт шинжилгээг 2022 оны 11 дүгээр сард зохион байгуулсан.

Хүснэгт 1. ОХШХ-ийн үзүүлэлтүүд

Гүйцэтгэгч / Хугацаа	Шинжилгээний үзүүлэлтүүд	
	Заавал шинжлүүлэх	Сонголтоор
Байгууламж ХХК Барилгын ажлын төгсгөлд 2022 оны 11 сард	<p>Нэг. Агаар 2 цэгт</p> <ul style="list-style-type: none"> ✓ азотын исэл ✓ хүхрийн исэл ✓ том ширхэгт тоосонцор ✓ нарийн ширхэгт тоосонцор ✓ нийт тоос ✓ дуу шуугианы хэмжээ <p>Хоёр. Бохир ус 2 цэгт</p> <ul style="list-style-type: none"> ✓ Химийн үзүүлэлтүүд: БХХ, ХХХ, ЖБ, рН, сульфид, аммиак ✓ Хүнд металлууд: Pb, Cd, Cr нийт, Cr VI, As ✓ Микробиологийн үзүүлэлтүүд: Гэдэсний бүлгийн эмгэг төрөгч нян /MNS 4943:2015/ <p>Гурав. Гадаргын ус 1 цэгт</p> <ul style="list-style-type: none"> ✓ Химийн үзүүлэлтүүд: БХХ, ХХХ, Ууссан хүчилтөрөгч, рН, аммиак, нитрит ✓ Хүнд металлууд: Pb, Cd, Cr нийт, Cr VI, As ✓ Микробиологийн үзүүлэлтүүд: Колититр, эмгэг төрүүлэгч нян, ББЕТ /Гадаргын усны цэврийн зэргийн ангилал/ 	<ul style="list-style-type: none"> ✓ гадаргуугийн идэвхит бодис, өөх тос ✓ Ni, Al, Cu, Mn, Fe ✓ Clostridium perfringens ✓ Ерөнхий химийн үзүүлэлтүүд, нийт азот, нийт фосфор ✓ Ni, Al, Cu, Mn, Fe

7.1 Хяналт шинжилгээний дээж авалт

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг төлөвлөсөн цэгүүдээс үндэсний дээж авах стандартын дагуу, дээж авах үеийн протокол үйлдэн гүйцэтгэсэн.



Зураг 4. ОХШХ-ийн цэгүүдийн байршил

Хүснэгт 2 Мониторинг хийсэн цэгийн үндэслэл болон координат

Агаарын хэмжилтийн цэг	Координат	Цэг сонгосон үндэслэл
<i>Агаарын чанар</i>		
1	1-р цэг буюу ЦБ-ын гадна талбай N 49° 30' 32.7" E 105° 55' 39.0"	Хяналтын цэг цэвэрлэх байгууламж болон хот суурин газрын нөлөөнд өртөөгүй талбайг сонгосон
2	2-р цэг Буюу ЦБ-ын барилгын ажлын талбай N 49° 30' 27.52" E 105° 55' 33.70"	Тээврийн хэрэгсэл болон барилгын ажил идэвхтэй явагдаж байгаа талбайг сонгосон
<i>Усны хэмжилтийн цэг</i>		
1	1-р цэг ЦБ руу орж ирж байгаа бохир усны хэсэг N 49° 30' 32.1" E 105° 55' 22.4"	2018 оны хяналт шинжилгээгээр аэротенкийн цэгүүдээс авсан хөрс усны шинжилгээний дүн хүнд металлын агууламж өндөр илэрсэн учир ЦБ руу орж ирж байгаа бохир усны хүнд металлын агууламжийг тогтоох зорилгоор оролт гаралтын хэсгээс усны дээжлэлт авахаар дараах 2 цэгийг сонгосон
2	2-р цэг ЦБ-аас цэвэршүүлээд байгалийн ус руу гарч байгаа хэсэг N 49° 30' 31.7" E 105° 55' 30.6"	
3	3-р цэг Хараа голын ус N 49° 30' 47.01" E 105° 53' 54.7"	Гадаргын усны хяналт шинжилгээ



Дархан Хотын Бохир Усны Менежментийг Сайжруулах МОН 3244/3245 төслийн А1 Багцын хүрээнд шинээр баригдах цэвэрлэх байгууламжийн талбайн Байгаль Орчны Хяналт Шинжилгээний Тайлан, 12 сар 2022 он

Бохир уснаас дээж авахдаа Монгол улсын “MNS ISO 5667-10:2001 Хаягдал уснаас дээжлэлт хийх удирдамж”, гадаргын уснаас дээж авахдаа MNS ISO 5667-6:2001-ийг мөрдлөг болгон ажилласан. Усны дээжийг зориулалтын аргаар ариутгасан шил болон 1 литрийн багтаамжтай хуванцар саванд авсан. Уснаас дээж авахдаа савыг дүүргэн авч саванд агаар байх зайгүйгээр тагласан. Энэ нь тээвэрлэлтийн үед сэгсрэгдэх, хийнүүдийн хоорондох харилцан үйлчлэлийг хязгаарлах ач холбогдолтой.



Цэвэрлэх байгууламжийн бохир усны дээж авалт



Гадаргын усны дээж авалт

Агаарын шинжилгээний дээж

7.2 Хяналт шижилгээнд ашигласан багаж

Байгаль орчны хяналт шинжилгээний ажлын хүрээнд тухайн төслийн талбайд агаарын чанарын үзүүлэлтүүд болох азотын давхар исэл (NO₂), хүхэрлэг хий (SO₂), нарийн ширхэгт тоосонцор (PM_{2.5}), том ширхэгт тоосонцор (PM₁₀)-ыг AEROQUAL SERIES 500 багаж ашиглан тодорхойлсон. Цэвэрлэх байгууламжийн эзэмшил талбай болон гадна талбайгаас агаарт агуулагдах SO_x, NO_x, нарийн ширхэгт тоосонцор (PM_{2.5}), том ширхэгт тоосонцор (PM₁₀) болон дуу шуугианыг тус бүр хэмжив. Агаарын чанарын хэмжилтийн явцад агаарын температур -15 °C - -18 °C, харьцангуй чийг 65%, даралт 1039Pha, хур тунадас 0мм, салхины хурд 9км/ц.

Хэмжилтийн цэг 1 – Цэвэрлэх байгууламжийн талбайд

Хэмжилтийн цэг 2 – Цэвэрлэх байгууламжийн гадна талбайд



Дархан Хотын Бохир Усны Менежментийг Сайжруулах МОН 3244/3245 төслийн А1 Багцын хүрээнд шинээр баригдах цэвэрлэх байгууламжийн талбайн Байгаль Орчны Хяналт Шинжилгээний Тайлан, 12 сар 2022 он

Орчны дуу шуугианы түвшийг CASELLA CEL-63X багажийг ашиглан тодорхойлохдоо (Зураг 4) FAST хүрээнд тохируулан хэмжсэн. Мөн хэмжилтийн алдааг хянах үүднээс хэмжилт бүрийн өмнө багажийг ACOUSTIC CALIBRATOR - CLASS 2 калибратор ашиглан шалгасан. Хэмжилтийн алдаа 0.2-оос бага байхад тохиромжтой гэж үзнэ.




7.3 Хяналт шинжилгээний үр дүн

А. Агаарын чанар

Агаарын чанарын хяналтын 2 цэгт хийсэн нарийн болон том ширхэгт тоосонцрын хэмжилтийг “MNS 4585:2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага” стандартын хүлцэх агууламжтай харьцуулахад стандартаас хэтэрсэн үзүүлэлтгүй байна. Хэмжилтийн үр дүнг **Error! Reference source not found.**-т ЗДХ-тэй харьцуулав.

Хүснэгт 3. Шинжилгээний үр дүн, тоосонцор

Цэвэрлэх байгууламжийн талбайд			Цэвэрлэх байгууламжийн гадна талбайд		
Хэмжилт	PM _{2.5}	PM ₁₀	Хэмжилт	PM _{2.5}	PM ₁₀
	мкг/м ³			мкг/м ³	
2022 оны 12-р сар	20	30	2022 оны 12-р сар	44	46
MNS 4585:2016 зөвшөөрөгдөх дээд хэмжээ	50	100	MNS 4585:2016 зөвшөөрөгдөх дээд хэмжээ	50	100





Тоосонцрын хэмжилтийн үр дүнг “MNS 4585:2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага” стандартын 24 цагийн хүлцэх агууламжтай харьцуулахад:


Цэвэрлэх байгууламжийн талбайд болон гадна талбайд агаарын нарийн, том ширхэгт тоосонцрын дундаж агууламж Монгол улсын агаарын чанарын MNS4585:2016 стандартын зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтрээгүй байна.

Агаар бохирдуулагч бодисын хэмжилт

Агаарын чанарын хяналтын 2 цэгээс авсан хүхэрлэг хий, нитритийн агууламж “MNS 4585:2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага” стандартын 24 цагийн хүлцэх агууламжаас давсан үзүүлэлт илрээгүй хэвийн хэмжээнд байна.

Хүснэгт 4. Агаар бохирдуулагч бодисын шинжилгээний үр дүн

№	Цэвэрлэх байгууламжийн талбайд	NO ₂	SO ₂	Цэвэрлэх байгууламжийн гадна талбайд	NO ₂	SO ₂
		мкг/м ³			мкг/м ³	
1	2022.12	16	16	2022.12	40	42
MNS4585:2016 ЗДХ		50 мкг/м ³	50 мкг/м ³	MNS4585:2016 ЗДХ	50 мкг/м ³	50 мкг/м ³



Хэмжилийн 30 минутын хугацаан дахь азотын давхар исэл болон хүхэрлэг хийн дундаж агууламж, стандартуудтай харьцуулалт

Дуу шуугианы хэмжилт

Доорх хүснэгтэд дуу шуугианы хяналт шинжилгээний 2 цэгийн хээрийн хэмжилтийн мэдээг Монгол улсын “Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага” MNS 4585:2016 стандарттай харьцуулж харуулав. Тус стандартад заасны дагуу өдрийн цагаар (07-22 цаг) гадаад орчны дуу шуугианы зөвшөөрөгдөх дээд хэмжээ 60 дБа байна.

Хүснэгт 5. Дуу шуугианы хэмжилтийн үр дүн

№	Мониторингийн цэг	Хэмжилт хийсэн цаг	Шуугианы эквивалент түвшин Leq, дБа				MNS 4585:2016 дБа
			L10	L50	L90	Leq	
1	Төслийн талбайд	11:06 – 11:21	58.4	50.6	45	55.4	60
2	Байгууламж дотор	12:21 – 12:37	90.7	85.2	55.5	86.2	-



Төслийн талбайд хийсэн дуу шуугианы мониторинг судалгааны үр дүнд үндэслэн дараах дүгнэлтүүдийг хийж байна. Үүнд:

1. Дуу шуугианы хяналт шинжилгээний 1-р цэг дэх хэмжилтийн эквивалент утга 55,4 дБА байсан нь MNS 4585:2016 стандартад заасан өдрийн цагаар (07-22 цаг) зөвшөөрөгдөх дээд хэмжээ болох 60 дБА-аас хэтрээгүй байна. Нийт хэмжилтийн 10% нь 58.4 дБА-с дээш, 50% нь 50.6 дБА-с дээш, 90% нь 45 дБА-с дээш утга үзүүлсэн байна. Эдгээр утгууд нь хоорондоо ойролцоо байгаа нь тухайн орчин дахь дуу шуугианы түвшин жигд байгааг илтгэнэ.
2. Дуу шуугианы хяналт шинжилгээний 2-р цэг дэх хэмжилтийн эквивалент утга 86.2 дБА байсан. Нийт хэмжилтийн 10% нь 90.7 дБА-с дээш, 50 % нь 85.2 дБА-с дээш, 90% нь 55.5 дБА-с дээш утга үзүүлсэн байна. Хэмжилт хийж байхад байгууламж дотор төмөр хоолой таслагч хөрөө рам, өнгөлгөөний машин ажиллаж байсан тул шуугианы түвшин өндөр гарсан. Дотор хэмжсэн учир гадаад орчны агаарын чанартай харьцуулах шаардлагагүй. Энэ дүн нь ХАБ-ийн асуудалтай илүү холбоотой учир цаашдаа тухайн байгууламжид их шуугиан үүсгэн ажиллаж буй ажилчдын хөдөлмөрийн аюулгүй байдлын тоноглолд анхаарал хандуулах шаардлагатай. Түүнчлэн төмөр тайрах, өнгөлөх ажил байнга хийгдэхгүй тул 15 минутын үр дүнд үндэслэн шуугианы өдрийн 16 цагийн эквивалент утгыг тодорхойлох нь учир дутагдалтай.

Б. Усны чанар

Төв цэвэрлэх байгууламж руу орж ирэх бохир ус, цэвэршүүлэлт хийгдээд гарч байгаа гаралтын ус, гадаргын ус (Цэвэрлэх байгууламжаас гарч буй ус Хараа голд нийлэх хэсгийн ус)-наас дээжлэлт хийн шинжлүүлэв. **Гадаргын усыг** MNS 4586:1998 Усан орчны чанарын үзүүлэлт, Ерөнхий шаардлагатай, цэвэрлэх байгууламжийн **оролтын усыг** MNS 6561:2015 Хүрээлэн байгаа орчин. Усны чанар Ариутгах татуургын сүлжээнд нийлүүлэх хаягдал ус, Ерөнхий шаардлагатай, **гаралтын усыг** MNS 4943:2015 Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Хаягдал ус. Ерөнхий шаардлагатай тус бүр харьцуулав. Лабораторийн шинжилгээг харгалзах стандартуудтай харьцуулахад гадаргын ус буюу Цэвэрлэх байгууламжаас гарч буй ус Хараа голд нийлэх хэсгийн ус хромын агууламж 0.56 дахин их, бусад элементүүд стандартаас хэтэрсэн үзүүлэлтгүй байна.

Хүснэгт 6. Бохир усны хүнд металлын шинжилгээний үр дүн

№	Хүнд металл	Нэгж	Цэвэрлэх байгууламжийн Оролтын ус	MNS 6561:2015	Цэвэрлэх байгууламжийн Гаралтын ус	MNS4943:2015	Хараа голын ус	MNS 4586:1998
1	Зэс, Cu	мг/л	<0.02	1.0	<0.02	1.0	<0.02	0.01
2	Кадми, Cd	мг/л	<0.005	0.05	<0.005	0.03	<0.005	0.005
3	Никель, Ni	мг/л	<0.005	0.5	<0.005	0.2	<0.005	0.01
4	Хар тугалга, Pb	мг/л	0.01	0.2	<0.01	0.1	0.01	0.01
5	Хром, Cr	мг/л	0.14	1.0	0.23	0.3	0.09	0.05
6	Цайр, Zn	мг/л	0.06	5.0	<0.01	3.0	<0.01	0.01

Цэвэрлэх байгууламжийн цэвэршүүлээд гарч байгаа гаралтын усанд хийсэн шинжилгээний дүнг MNS 4943:2015 “Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Хаягдал ус. Ерөнхий шаардлага”-тай харьцуулав. Шинжилгээгээр цэвэрлэх байгууламж руу орж ирж байгаа



Дархан Хотын Бохир Усны Менежментийг Сайжруулах МОН 3244/3245
төслийн А1 Багцын хүрээнд шинээр баригдах цэвэрлэх байгууламжийн талбайн
Байгаль Орчны Хяналт Шинжилгээний Тайлан, 12 сар 2022 он

усанд аммони 102 мг/л байсан бол цэвэршүүлэгдээд гарч байгаа усанд 60 мг/л хэмжээтэй болж 1.7 дахин буурсан, харин умбуур бодисын хувьд оролтын усанд 50 мг/л хэмжээтэй, цэвэршүүлэгдээд гарч байгаа усанд <3.0 мг/л хэмжээтэй буюу стандартад заасан хэмжээнээс 10 дахин бага байна. Химийн хэрэгцээт хүчилтөрөгчийн хувьд оролтын усанд 420 мгО/л, цэвэршүүлэгдээд гарч байгаа усанд 44.0 мгО/л болж 9.5 дахин буурсан, стандартаас хэтэрсэн үзүүлэлтгүй байна.

Гадаргын усны рН 7.90, аммони (NH₄) 80.0 мгN/л, ууссан хүчилтөрөгч 0.90 мгО/л, умбуур бодис <3.0 мг/л стандартаас хэтэрсэн үзүүлэлтгүй байна. Нитрит (NO₂) 0.25 мгО/л стандартаас 12 дахин их, химийн хэрэгцээт хүчилтөрөгч (XXX) 36 мгО/л үзүүлэлттэй стандартаас 3.6 дахин их байна.

Хүснэгт 7. Бохир усны шинжилгээний үр дүн

Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	Шинжилгээний дүн Цэвэрлэх байгууламжийн		MNS 4943:2015	Шинжилгээний дүн	MNS 4586:1998
		Оролтын ус	Гаралтын ус		Хараа голын ус	
рН	-	7.84	7.81	6-9	7.90	6.5-8.5
NH ₄	мг/л	102.0	60.0	-	80.0	-
NO ₂	мг/л	<0.05	0.50	-	0.25	0.02
Хуурай үлдэгдэл,	мг/л	806.0	916.0	-	1092	-
ЦДЧ	µS/cm	1414.0	1671	-	1924	-
Умбуур бодис	мг/л	50.0	<3.0	30	<3.0	-
Ууссан хүчилтөрөгч	мгО/л	0.50	0.60	-	0.90	6 ба 4-с багагүй
XXX	мгО/л	420.0	44.0	50	36.0	10
Кальци, Ca ²⁺	мг/л	36.24	43.38	-	49.08	-



Микро биологийн шинжилгээ

Хүрээлэн буй орчин. Усны чанар. Хаягдал ус. Ерөнхий шаардлага MNS 4943:2015 стандартад Микробиологийн үзүүлэлтээс зөвхөн “Эмгэг төрөгч нян”-ийн үзүүлэлт тусгагдсан байдаг ба стандарттай харьцуулахад Хараа голын ус, цэвэрлэх байгууламжийн оролт гаралтын усны аль алинд нь эмгэг төрөгч нян 1 мл-т илрээгүй байна. 2022 оны 11-р сарын микробиологийн шинжилгээг харьцуулан Хүснэгт 8-г харуулав.

Хүснэгт 8. 2022 оны 11-р сарын усны микробиологийн шинжилгээний дүн

Үзүүлэлтүүд	Нэгж	Шинжилгээний дүн			MNS 4943:2015
		Цэвэрлэх байгууламжийн Оролтын ус	Цэвэрлэх байгууламжийн Гаралтын ус	Хараа голын гадаргын ус	
		2022.11.29			
Бактерийн ерөнхий тоо	1 мл-д	1.5*10 ⁶	1.1*10 ⁵	1.1*10 ⁵	-
Гэдэсний савханцрын таньц	мл	Илрэв (<0.000004)	Илрэв (<0.0004)	Илрэв (<0.0004)	-
Халуунд тэсвэртэй гэдэсний бүлгийн савханцрын таньц	мл	Илрэв (<0.000004)	Илрээгүй	Илрээгүй	-
Клостридиум перфрингенсийн таньц	мл	Илрэв (0.00001)	Илрэв (0.01)	Илрэв (0.01)	-
Гэдэсний бүлгийн эмгэг төрөгч нян (Salmonella)	1 мл-д	Илрээгүй	Илрээгүй	Илрээгүй	илрэхгүй

Дүгнэлт

Цэвэрлэх байгууламжийн цэвэршүүлээд гарч байгаа гаралтын усанд хийсэн шинжилгээний дүнг MNS 4943:2015 “Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Хаягдал ус. Ерөнхий шаардлага”-тай харьцуулав. Шинжилгээгээр цэвэрлэх байгууламж руу орж ирж байгаа усанд аммони 102 мг/л байсан бол цэвэршүүлэгдээд гарч байгаа усанд 60 мг/л хэмжээтэй болж 1.7 дахин буурсан, харин умбуур бодисын хувьд оролтын усанд 50 мг/л хэмжээтэй, цэвэршүүлэгдээд гарч байгаа усанд <3.0 мг/л хэмжээтэй буюу стандартад заасан хэмжээнээс 10 дахин бага байна. Химийн хэрэгцээт хүчилтөрөгчийн хувьд оролтын усанд 420 мгО/л, цэвэршүүлэгдээд гарч байгаа усанд 44.0 мгО/л болж 9.5 дахин буурсан, стандартаас хэтэрсэн үзүүлэлтгүй байна.

Гадаргын усны рН 7.90, аммони (NH₄) 80.0 мгN/л, ууссан хүчилтөрөгч 0.90 мгО/л, умбуур бодис <3.0 мг/л стандартаас хэтэрсэн үзүүлэлтгүй байна. Нитрит (NO₂) 0.25 мгО/л стандартаас 12 дахин их, химийн хэрэгцээт хүчилтөрөгч (XXX) 36 мгО/л үзүүлэлттэй стандартаас 3.6 дахин их байна.

Микробиологийн шинжилгээгээр Хараа голын ус, цэвэрлэх байгууламжийн оролт, гаралтын усанд эмгэг төрөгч нян 1 мл-т илрээгүй байна.



8. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

Төслийн хүрээнд 2022 онд байгаль орчны удирдлага, зохион байгуулалтын 3 арга хэмжээ төлөвлөсөн бөгөөд нийт гүйцэтгэл 100% байна.

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Биелэлт	%	Фото зураг
1	Ажилчдад эрүүл мэндтэй холбоотой сургалт зохион байгуулах, урьдчилан сэргийлэх зөвлөмж мэдээллээр хангах	Ажилчдад хөдөлмөрийн аюулгүй байдал болон эрүүл мэндтэй холбоотой сургалтыг зохион байгуулсан.	100	
2	Байгаль орчны аудит хийлгэх	Төслийн шинэ гүйцэтгэгч 2022 оны 11 дүгээр сард шалгарч, АХБ наас зөвшөөрөл авсан гэрээ байгуулан ажиллаж буйтай холбоотой байгаль орчны аудитыг 2023 онд хийхээр төлөвлөсөн.	-	-
3	Байгаль орчны аудитын тайланд орсон үл нийцлүүдийг арилгах залруулах	Төслийн шинэ гүйцэтгэгч 2022 оны 11 дүгээр сард шалгарч, АХБ наас зөвшөөрөл авсан гэрээ байгуулан ажиллаж буйтай холбоотой байгаль орчны аудитыг 2023 онд хийхээр төлөвлөсөн.	-	-
Нийт биелэлт			100	

9. Нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Биелэлт	%	Фото зураг
